

***Өмнөговь аймгийн орон нутгийн өмчит “Тавантолгой”ХК-ийн уурхайн үйл ажиллагаатай танилцах, зочлох журам.***

Нийтлэг зүйл.

“Тавантолгой” ХК-ийн уурхайн үйл ажиллагаатай танилцах, зочлох иргэд, ААНБайгууллагууд энэхүү журмыг мөрдөнө.

Нэг. Уурхайн үйл ажиллагаатай танилцах аж ахуй нэгж, байгууллага, иргэд өөрийн албан хүсэлт болон өргөдлийг 24 цагийн өмнө өгсөн байна. (И-мэйлээр болон бичгээр) Үүнд:

- Танилцах тухай үндэслэл
- Хүмүүсийн овог нэр
- Регистрийн дугаар

Хоёр. Уурхайд нэвтрэх зөвшөөрлийг зөвхөн гүйцэтгэх захирал ба түүнийг орлож байгаа ажилтан өгнө. Зөвшөөрөл олгосны дараа зочны үнэмлэх олгоно.

Гурав. Уурхайтай танилцах үед та дараах шаардлагыг хангасан байна.

1. Согтууруулах болон мансууруулах бодис хэрэглээгүй байх. ( шаардлагатай тохиолдолд драгер үлээлгэнэ)
2. Галт зэвсэг болон элдэв хориотой зүйл биедээ авч явахгүй байх. (машин техникээ шалгуулах үүрэгтэй)
3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч гарын үсэг зурж баталгаажуулсан байх.
4. Уурхайгаас тавьж өгсөн хамгаалах хэрэгсэл хэрэглэсэн байх.
5. Тавантолгой ХК -иас томилогдсон хөтөч, зааварлагчийн зааврын дагуу явах.
6. Суудлын бүс болон дуут дохиог зааврийн дагуу хэрэглэх.
7. Тээврийн хэрэгслийн хурдыг 40 км цагаас хэтрүүлэхгүй явах.
8. Уурхайн ашиглалтын бүсэд элдэв хог хаягдал хаяхгүй байх.
9. Тээврийн хэрэгслийн бүх гэрэлтүүлгийг асаасан байх.
10. Ажлын цагаар зочдыг хүлээж авах болно.

Дээрхи шаардлагыг хангаагүй тохиолдолд бид таныг уурхайд нэвтрүүлэх боломжгүй юм.